

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/212 тоот захирамжийг үндэслэн дор дурдсан байршилд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний төсөл сонгон шалгаруулалт цахим хэлбэрээр /интернетээр/ зохион байгуулахаар зарлаж байна.

1. Төсөл сонгон шалгаруулалтын хэлбэр: Цахим хэлбэрээр /Интернетээр/ Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөл сонгон шалгаруулалтын журам”-ын дагуу дараах 1 байршилд газар эзэмших ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явагдана.

I. Сүмбэр сум 1 дүгээр багт ЦДҮСТӨХК-ны баруун урд талд 50 гагазрыг нарны цахилгаан станцын зориулалтаар

2. Эзэмшүүлэх хугацаа: 15 жил /арван таван/

3. Төслийн баримт бичгийг бичгээр хүсэлт гарган, эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 250000 төгрөгөөр Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 102 тоот өрөөнөөс авна

4. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан хураамж буюу 12500 төгрөгийг 100220500941 дансанд тушаасан байх.

5. Газрын үнэ 10000000 /арван сая/ төгрөг.

6. Гэрээний зүйл: Сүмбэр сумын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд заасны дагуу газар ашиглахтай холбогдсон зураг төслийг газар эзэмших гэрээ байгуулснаас хойш 6 сарын дотор багтаан боловсруулж ирүүлнэ.

7. Цахим хуудас: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар нэвтэрч оролцоно.

8. Төсөл сонгон шалгаруулалтын оролцогчдыг бүртгэх хугацаа: Оролцогчдыг 2018 оны 03 сарын 05-ны 08 цаг 30 минутаас эхлэн 2018 оны 03 дугаар сарын 22-ны 12 цаг 30 минут хүртэл төсөл хүлээн авч, баталгаажуулна.

9. Төсөл сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалыг нээх хугацаа: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 15:00 цагт сүмбэр сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг Сүмбэр сумын ЗДТГ-ыниргэний танхимийн хурлын зааланд эхлэнэ.

10. Төсөл сонгон шалгаруулах үндсэн үзүүлэлтүүд архитектор төлөвлөлтийн даалгавар, гэрээний ерөнхий нөхцөл, техникийн ерөнхий нөхцөл, барилга барих хугацаа, төсөл сонгон шалгаруулах журмаар олгох газрын хил хязгаар, заагийг харуулсан зураг схем нь төслийн баримт бичигт хавсарагдана.


11. Газрын байршил, хил хязгаарын зураг схем:

X=295018.73 Y=5130361.77

X=296252.56 Y=5131570.88

X=296344.84 Y=5131340.64

X=295129.63 Y=5129987.90



Холбоо барих утас: 70543249, 99609028